



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 023

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээх зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол-Ус” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 16 нэрийн 23,351,874.00 (хорин гурван сая гурван зуун тавин нэгэн мянга найман зуун далан дөрөв) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, “Монгол-Ус” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Билэгсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

"Монгол-Ус" ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он сар өдөр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Хөргөгч	2009.12.09	ш	1	719,991.00	719,991.00	719,991.00	0.00
2	Ширээ /зөвөлгөөний/	2009.01.30	ш	1	923,180.00	923,180.00	923,180.00	0.00
3	Ширээ/даргын/	2009.01.30	ш	1	796,615.00	796,615.00	796,615.00	0.00
4	Бичгийн шкаф/саарал/	2011.01.19	ш	1	240,000.00	240,000.00	240,000.00	0.00
5	Термостат GSP-9050MBE	2010.02.01	ш	1	1,547,000.00	1,547,000.00	1,547,000.00	0.00
6	Автоклав YXQ-LS-18SI	2010.02.01	ш	1	1,690,000.00	1,690,000.00	1,690,000.00	0.00
7	Аналитик жин	2010.02.01	ш	1	1,742,000.00	1,742,000.00	1,742,000.00	0.00
8	Электрон жин ОНАУС-600	2010.02.01	ш	1	507,000.00	507,000.00	507,000.00	0.00
9	Колбо сэгсрэгч WSZ-100A	2010.02.01	ш	1	2,002,000.00	2,002,000.00	2,002,000.00	0.00
10	Центерфуги KA1000	2010.02.01	ш	1	1,924,000.00	1,924,000.00	1,924,000.00	0.00
11	Цах дам чанар хэм MP513	2010.02.01	ш	1	1,287,000.00	1,287,000.00	1,287,000.00	0.00
12	Хээрийн лабораторийн багаж	2010.02.01	ш	1	5,224,000.00	5,224,000.00	5,224,000.00	0.00
13	Шкаф бодис хадгалах шилэн нүүр	2012.08.22	ш	1	649,000.00	649,000.00	649,000.00	0.00
14	Шкаф бодис хадгалах шилэн нүүр	2012.08.22	ш	1	649,000.00	649,000.00	649,000.00	0.00
15	Лаб шинжилгээний ширээ ком	2009.01.30	ш	1	1,491,088.00	1,491,088.00	1,491,088.00	0.00
16	Дөрвөн ханатай гэр	2013.01.12	ш	1	1,960,000.00	1,960,000.00	1,960,000.00	0.00
	<b>Нийт дүн</b>			<b>16</b>		<b>23,351,874.00</b> (хорин гурван сая гурван зуун тавин нэгэн мянга найман зуун далан дөрөв)	<b>23,351,874.00</b> (хорин гурван сая гурван зуун тавин нэгэн мянга найман зуун далан дөрөв)	